

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2021 оны 09 сарын 28-ний

№ ХХГ/2021/.....

Улаанбаатар хот

Энэхүү худалдах, худалдан авах гэрээ /Цаашид "Гэрээ" гэх/-г
Нэг талаас: "Таван толгой түлш" ХХК-нийг бодлого төлөвлөлт маркетинги
харуцсан захирал **Г.Ундармаа** (цаашид "Худалдагч" гэх)

Нөгөө талаас: "Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ"-ыг төлөөлж Хангамж
үйлчилгээний албаны дарга **Э.Энхгэрэл** нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн
илэрхийлж Монгол улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн дараах
нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх
зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо
бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн
зөвшөөрөв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго:

1.1.1. Худалдагч нь **150,000** тонн сайжруулсан шахмал
түлшийг /цаашид бараа/ гэх, түүнтэй холбоотой баримт бичгийн хамт худалдан авагчийн
өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр
тооцоог гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.2.1 Сайжруулсан шахмал түлш нийлүүлэх хуваарь / Хавсралт №1 /

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

2.1 Гэрээний үнэ:

2.1.1 Сайжруулсан шахмал түлшний нэг тонн үнэ **150,000 /зуун тавин мянган
төгрөг/**

2.1.2 Гэрээний үнэд тээврийн бичиг баримт хийгдэх хүртэлх бүх зардал буюу
"Таван толгой түлш" ХХК-ний пүүгээр жинлэх орсон бөгөөд автомашинд ачих, тээврийн
зардал ороогүй болно.

2.1.3 Гэрээний хэрэгжилтийн явцад шинээр батлагдсан хууль, төрийн аливаа
шийдвэрүүдэд нэмэлт болон өөрчлөлт орсон нь гэрээний үнэд өөрчлөлт орох үндэслэл
болохгүй.

2.1.4 Гэрээний үнийн дүнг "Таван толгой түлш" ХХК-ний **Хаан** банкны
5038080523 тоот дансанд хийх.

2.2 Гэрээний үнийг төлөх нөхцөл:

2.2.1 Гэрээ нь урьдчилгаа төлбөргүй болно.

2.2.2 Гэрээний Хавсралт №1-т заасан жагсаалт зааснаар үнэ төлнө.

2.2.3 Худалдан авагч нүүрсний үнийг хугацаандаа төлөөгүй хугацаа хэтрүүлсэн
тохиолдолд хэтрүүлсэн хоног тутам төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх
алданги худалдагч талд төлнө.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, БАРАА ХҮЛЭЭН АВАХ, ӨМЧЛӨХ

3.1 Гэрээний хугацаа:

3.1.1 Сайжруулсан шахмал түлшийг гэрээний Хавсралт №1-т заасан хугацааны
дотор Худалдагч нь Худалдан авагчид бүрэн хэмжээгээр хүлээлгэн өгнө. Хэрэв

Худалдагчийг төлөөлж

Худалдан авагчийг төлөөлж

хугацаандаа хуваарийн дагуу нийлүүлж дуусаагүй бол дараа сарын хуваарь дээр нэмж нийлүүлнэ.

3.1.2 Сайжруулсан шахмал түлшийг нийлүүлэх хугацаанд байгалийн гэнэтийн үзэгдэл болон гамшгаас үүдэн гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд Худалдагч Худалдан авагчид урьдчилан бичгээр мэдэгдэж нийлүүлэх хугацааг тохиролцох эсвэл гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авна.

3.1.3 Худалдан авагч сарын хуваарьт нүүрснээс илүү эсвэл дутуу нүүрс авахаар бол худалдагчид урьдчилан мэдэгдэж тохиролцоно.

3.2 Бараа бүтээгдэхүүний доголдол:

3.2.1 Сайжруулсан шахмал түлшийг хүлээн авснаас хойш шавар, чулуу, шороо, нүүрснээс бусад шатах боломжгүй хольц нэг тонн шахмал түлшинд 5%-аас их хэмжээний гологдол гарвал 2 тал хамтран комисс томилж мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 15 хоногийн дотор газар дээр нь акт үйлдэж нийт жин тонноос хасаж тооцно.

3.2.2 Хэрэв хугацаа хэтэрвэл уг барааны анхны үнийн дүнгийн 0,1 хувиар алданги тооцон Худалдан авагчид төлнө.

3.3 Бараа, бүтээгдэхүүн хүлээн авах, хүлээлгэн өгөх:

3.3.1 Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг Хавсралт №1-т заасан хуваарийн дагуу нийлүүлэх ба уг хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

3.3.2 Ачуулсан шахмал түлшний тоо хэмжээг Худалдагч талын автомашин пүүний баримт, талуудын эрх бүхий төлөөлөгчдийн гарын үсгээр баталгаажиж хүлээлцсэн, ачаа тээврийн дагалдах баримт бичиг мөн түүнтэй хамт хавсаргасан худалдагчийн падаан, ачаа хүлээлгэн өгсөн акт зэргийг үндэслэн ачааны жинг тооцно.

3.3.3 Худалдагч сайжруулсан шахмал түлшийг "Таван толгой түлш" ХХК-ний 1-р үйлдвэрээс хүлээлгэн өгөх бөгөөд худалдан авагч ийнхүү барааг хүлээн авснаас хойш бараанд аливаа учрах эрсдэл болон тээврийн зардлыг бүрэн хариуцна.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Худалдагчийн хариуцлага, эрх, үүрэг:

4.1.1 Сайжруулсан шахмал түлшийг гэрээнд заасан стандартын дагуу заагдсан хугацаанд, холбогдох баримт бичгийн хамт шилжүүлэх.

4.1.2 Худалдан авагчид хүлээлгэн өгөх хүртэл зориулалт, хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, бүрэн бүтэн байдал, эрсдэлийг хариуцах,

4.1.3 Сайжруулсан шахмал түлшний талаар үнэн зөв, бүрэн мэдээллийг өгөх,

4.1.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлээгүйгээс нөгөө талдаа учруулсан хохирлыг нөхөн төлөх,

4.1.5 Худалдагч нь сайжруулсан шахмал түлш нийлүүлэхдээ гэрээний Хавсралт №1-т заасан нийлүүлэлтийн хуваарийг хатуу мөрдөх,

4.1.6 Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх,

4.1.7 Гэрээний үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг Худалдан авагчаас шаардах,

4.1.8 Худалдан авагч сайжруулсан шахмал түлшний үнийг төлөх хугацаагаа 15 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд дараагийн нийлүүлэлтээ зогсоох буюу татгалзах,

4.2 Худалдан авагчийн хариуцлага, эрх, үүрэг:

4.2.1 Бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхийг шаардах,

4.2.2 Бараа бүтээгдэхүүнд гологдол илэрвэл доголдлыг арилгуулах, ижил төрлийн бараагаар солиулах, гологдлыг арилгахад гарсан зардлаа төлүүлэх,

Худалдагчийг төлөөлж.....

Худалдан авагчийг төлөөлж.....

4.2.3 Сайжруулсан шахмал түлш нь стандартын шаардлага хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор Худалдан авагч эсхүл түүний төлөөлөгч сайжруулсан шахмал түлшийг шалгах, туршилт хийх,

4.2.4 Шалгалт, туршилтаар бараа нь сайжруулсан шахмал түлш нь стандартын шаардлага хангаагүй тохиолдолд Худалдан авагч нь татгалзах эрхтэй ба Худалдагч нь тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээг авах,

4.2.5 Гэрээний 4.2.3-д заасан Худалдан авагч нь шалгаж, туршсан аль ч нөхцөл, болзол нь Худалдагчийг гэрээний бусад үүргээс чөлөөлөхгүй,

4.2.6 Бараа бүтээгдэхүүний үнийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх,

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1 Гэрээ цуцлах:

5.1.1 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах бол талууд бие биедээ ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

5.1.2 Дараах тохиолдолд гэрээг Худалдан авагч өөрийн санаачилгаар цуцална. Үүнд:

а/ Бараа бүтээгдэхүүн нь гэрээнд заасан чанарын шаардлага, бусад үзүүлэлтийг хангаагүй.

б/ Бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд худалдан авагчид шилжүүлээгүй.

5.2 Маргаан шийдвэрлэх:

5.3.1 Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана.

5.3.2 Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

5.3.3 Гэрээний хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.5 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах:

5.5.1 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа нэг тал нөгөө талдаа харилцан тохирсноос бусад тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.

5.5.2 Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

5.5.3 Нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

5.8 Гэрээ хүчин төгөлдөр болох:

5.8.1 Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.8.2 Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.

5.8.3 Энэхүү гэрээний 1.2-т заасан хавсралт болон бусад бичиг баримтууд дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзнэ.

5.8.4 Гэрээ болон түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Худалдагчийг төлөөлж



Худалдан авагчийг төлөөлж



ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

А ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
"Тавантолгой түлш" ХХК-ийн
Бодлого төлөвлөлт маркетингийн
хариуцсан захирал захирал
Г.Ундармаа.....

Хуулийн мэргэжилтэн:
Г.Гансүх.....

Утас: 75005555

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Б ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
Улаанбаатар, Баянгол дүүрэг 17-р
хороо, РТҮС-УТҮГ-ийн байр
"Радио телевизийн үндэсний сүлжээ
УТҮГ"-ын Хангамж үйлчилгээний
албаны дарга Э.Энхгэрэл.....

Маркетингийн мэргэжилтэн:

Ц.Тэмүүлэн.....

Утас: 75112020



Худалдагчийг төлөөлж.....

Худалдан авагчийг төлөөлж.....